



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Зүүнбаян тохижилтын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сайншанд сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор:

Цахим хаяг:

Аудитын менежер:

Цахим хаяг:

Ахлах аудитор:

Цахим хаяг:

Аудитор:

Цахим хаяг:

Т.Ган-Өлзий

dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

oyuntulkhuur.u@audit.gov.mn

Б.Болормаа

info.iedca@gmail.com

Д.Батчимэг

info.iedca@gmail.com



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.25 № 1-6/86

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗҮҮНБАЯН ТОХИЖИЛТЫН
АЛБАНЫ ДАРГА З.АМАРСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Зүүнбаян тохижилтын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 23.8 сая төгрөгийн төгрөгийн дизель түлшийг худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн

442505061

олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,181,180.00	26,009,810.59
335	Бусад авлага		13,323,910.59
3351	Байгууллагаас авах авлага		13,323,910.59
35	БАРАА МАТЕРИАЛ	10,181,180.00	12,685,900.00
354	Хангамжийн материал	10,181,180.00	12,685,900.00
35410	Бичиг хэргийн материал	38,080.00	39,940.00
35420	Аж ахуйн материал	6,694,150.00	5,309,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	499,500.00	499,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,949,450.00	6,837,360.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	569,826,880.71	665,452,510.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	569,826,880.71	665,452,510.99
392	Биет хөрөнгө	58,998,880.71	154,624,510.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	27,854,358.52	27,854,358.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,501,348.76	-25,454,814.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,000,000.00	134,082,333.36
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,000,000.00	-50,403,921.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,839,333.00	38,839,333.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,952,478.89	-35,302,228.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,249,500.00	3,249,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,046,989.18	-3,191,864.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	152,640,142.76	189,567,683.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	-105,087,636.74	-124,619,868.62
39217	Ном	4,000.00	4,000.00
393	Биет бус хөрөнгө	510,828,000.00	510,828,000.00
39301	Програм хангамж	2,127,000.00	2,127,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,127,000.00	-2,127,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	510,828,000.00	510,828,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	580,008,060.71	691,462,321.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	580,008,060.71	691,462,321.58
51	Засгийн газрын хувь оролцоо	580,008,060.71	691,462,321.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	574,314,842.00	574,314,842.00
51101	Өмч: - төрийн	574,314,842.00	574,314,842.00
512	Хуримтлагдсан үр дүн	-54,905,492.13	56,548,768.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-54,905,492.13	-54,905,492.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	111,454,260.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,598,710.84	60,598,710.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	580,008,060.71	691,462,321.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	568,153,616.44	657,532,364.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	126,070,564.64
120	Нийтлэг татварын бус орлого	-	126,070,564.64
120009	Бусад орлого	-	60,690.28
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		126,009,874.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	568,153,616.44	531,461,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,415,000.00	25,005,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,415,000.00	25,005,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	557,738,616.44	506,456,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	557,738,616.44	506,456,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	580,232,628.62	546,078,103.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	580,232,628.62	546,078,103.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,232,628.62	485,735,004.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,325,482.20	347,031,563.01
210101	Үндсэн цалин	176,339,765.20	153,956,380.90
210102	Нэмэгдэл	116,390,362.00	101,848,890.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,617,027.00	25,250,000.00
210104	Урамшуулал	23,501,800.00	15,892,862.03
210105	Гэрээт ажлын хөлс	59,476,528.00	50,083,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,400,337.76	39,940,421.50
210201	Тэтгэврийн даатгал	30,966,657.76	23,153,421.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,378,520.00	4,200,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,004,110.00	3,360,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	818,810.00	947,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,232,240.00	8,280,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,493,882.21	16,716,666.71
210301	Гэрэл, цахилгаан	1,131,215.21	1,058,947.71
210302	Түлш, халаалт	23,417,847.00	12,463,759.00
210303	Цэвэр, бохир ус	2,944,820.00	3,193,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,073,220.00	34,475,180.00
210401	Бичиг хэрэг	1,078,260.00	568,340.00
210402	Тээвэр, шатахуун	21,999,600.00	20,102,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,795,360.00	13,354,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	143,000.00
210604	Урсгал засвар	-	143,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,458,599.14	17,043,929.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,601,751.14	15,251,505.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	864,000.00
210807	Газрын төлбөр	1,856,848.00	928,424.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,122,307.31	30,384,244.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,122,307.31	30,384,244.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	60,343,099.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	60,343,099.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	60,343,099.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-12,079,012.18	111,454,260.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-12,079,012.18	111,454,260.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>383,332,116.44</u>	<u>531,522,490.28</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	60,690.28
120	Нийтлэг татварын бус орлого	-	60,690.28
120009	Бусад орлого	-	60,690.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	383,332,116.44	531,461,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,230,000.00	25,005,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,230,000.00	25,005,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,102,116.44	506,456,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,102,116.44	506,456,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>377,771,426.16</u>	<u>531,522,490.28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,771,426.16	531,522,490.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,771,426.16	457,855,480.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,543,478.10	347,031,563.01
210101	Үндсэн цалин	115,915,163.10	153,956,380.90
210102	Нэмэгдэл	86,118,360.00	101,848,890.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,232,027.00	25,250,000.00
210104	Урамшуулал	16,073,400.00	15,892,862.03
210105	Гэрээт ажлын хөлс	40,204,528.00	50,083,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,577,100.16	39,940,421.50
210201	Тэтгэврийн даатгал	21,793,100.16	23,153,421.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,223,000.00	4,200,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,630,300.00	3,360,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,100.00	947,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,392,600.00	8,280,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,264,921.55	16,716,666.71
210301	Гэрэл, цахилгаан	799,822.55	1,058,947.71
210302	Түлш, халаалт	12,463,699.00	12,463,759.00
210303	Цэвэр, бохир ус	2,001,400.00	3,193,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,410,100.00	28,769,300.00
210401	Бичиг хэрэг	606,500.00	589,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,487,700.00	23,990,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,165,900.00	3,740,100.00
2105	Нормативт зардал	6,000,000.00	3,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,191,880.00	5,353,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,691,880.00	3,353,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,783,946.35	17,043,929.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,991,522.35	15,251,505.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210807	Газрын төлбөр	928,424.00	928,424.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	73,667,009.59
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	73,667,009.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	60,343,099.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		13,323,910.59

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-54,905,492.13	580,008,060.71
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-54,905,492.13	580,008,060.71
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-54,905,492.13	580,008,060.71
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-54,905,492.13	580,008,060.71
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	-54,905,492.13	580,008,060.71
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	111,454,260.87	111,454,260.87
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,314,842.00	60,598,710.84	56,548,768.74	691,462,321.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	531,169,700.00	506,456,300.00	24,713,400.00	95.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,169,700.00	506,456,300.00	24,713,400.00	95.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,169,700.00	446,113,201.00	85,056,499.00	83.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,193,200.00	347,031,563.01	55,161,636.99	86.28
210101	Үндсэн цалин	172,641,200.00	153,956,380.90	18,684,819.10	89.18
210102	Нэмэгдэл	137,652,000.00	101,848,890.08	35,803,109.92	73.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,400,000.00	25,250,000.00	1,150,000.00	95.64
210104	Урамшуулал	11,500,000.00	15,892,862.03	(4,392,862.03)	138.20
210105	Гэрээт ажлын хөлс	54,000,000.00	50,083,430.00	3,916,570.00	92.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,887,000.00	39,940,421.50	12,946,578.50	75.52
210201	Тэтгэврийн даатгал	36,100,000.00	23,153,421.50	12,946,578.50	64.14
210202	Тэтгэмжийн даатгал	4,200,000.00	4,200,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,360,000.00	3,360,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	947,000.00	947,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,280,000.00	8,280,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,417,800.00	16,716,666.71	4,701,133.29	78.05
210301	Гэрэл, цахилгаан	2,048,300.00	1,058,947.71	989,352.29	51.70
210302	Түлш, халаалт	14,318,800.00	12,463,759.00	1,855,041.00	87.04
210303	Цэвэр, бохир ус	5,050,700.00	3,193,960.00	1,856,740.00	63.24
2104	Хангамж, бараа материалын зардал	22,422,600.00	22,374,100.00	48,500.00	99.78

210401	Бичиг хэрэг	390,000.00	365,700.00	24,300.00	93.77
210402	Тээвэр, шатахуун	19,000,000.00	18,990,000.00	10,000.00	99.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	457,600.00	450,000.00	7,600.00	98.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,575,000.00	2,568,400.00	6,600.00	99.74
2105	Нормативт зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,600,000.00	5,353,600.00	1,246,400.00	81.12
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,600,000.00	3,353,600.00	246,400.00	93.16
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,649,100.00	11,696,849.78	10,952,250.22	51.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,616,300.00	9,904,425.78	10,711,874.22	48.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	864,000.00	136,000.00	86.40
210807	Газрын төлбөр	1,032,800.00	928,424.00	104,376.00	89.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	60,343,099.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	60,343,099.00		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		60,343,099.00	(60,343,099.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	531,169,700.00	506,456,300.00	24,713,400.00	95.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	531,169,700.00	506,456,300.00	24,713,400.00	95.35
132001	Орон нутгийн төсвөөс	531,169,700.00	506,456,300.00	24,713,400.00	95.35

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,066,190.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,066,190.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,742,279.69
2104	Хангамж, бараа материалын зардал	6,395,200.00
210401	Бичиг хэрэг	223,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,171,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,347,079.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,347,079.69
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,323,910.59
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,323,910.59
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,066,190.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,005,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,005,500.00
120009	Бусад орлого	60,690.28

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13.3 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж аудитын явцад залруулсан.

- Нэмэлт санхүүжилтийн дансны 13.3 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн дүнгээр шууд зардалд тусгасныг авлага үүсгэн бүртгэлийг залруулсан

Аудитаар нийт 23.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд 23.8 сая төгрөгийн төгрөгийн дизель түлшийг худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын аргын аль нэгийн дагуу зохион байгуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын аргын аль нэгийн дагуу зохион байгуулж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 03 сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор албан тоот, нотлох баримтаар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн дансны 13.3 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн дүнгээр шууд зардалд тусгасныг авлага үүсгэн бүртгэлийг залруулсан	1	13,323.9			1	13,323.9	1	13,323.9	-	-	-	-
Дүн	1	13,323.9			1	13,323.9	1	13,323.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
											-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд 23.8 сая төгрөгийн төгрөгийн дизель түлшийг худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн	1						1	-
Дүн	1						1	-
Нийт дүн	1						1	-